

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо нь манай орны газар нутгийн 70 гаруй хувийг бүрдүүлж буй бэлчээр нутгаа зөв зохистой ашиглах, хамгаалахад бэлчээрийн салбарын бүхий л оролцогч, сонирхогч талуудыг холбох гүүр байгууллага юм.

Тус холбоо нь эртнээс уламжилсан малч ухаан, арга туршлага, судалгаа шинжилгээний бүтээл, гарын авлагыг сонирхогч талуудад бүтээлчээр хэрэглэх, үр огоожийг нь хүртэхэд,

арга
звйн
болоод
мэргэжлийн
зовлогоо
огч, зов
звйтэй
vvсгэл
санаачлагыг
дэмжин
дэлгэрvvлдэг
.

Бэлчээрийн менежментийн чиглэлээр суралцаж, ажиллаж, судалгаа шинжилгээ хийж б
айгаа

,
Монгол
орны
бэлчээрт
санаа
зовнигч
хэн
bvхэнд
тус
холбооны
гишvvнчлэл
нээлттэй
.

Гишvvнчлэлийн
асуудлыг
тусгай
журмаар
зохицуулдаг
.

Эрхэм зорилго:

МБМХ нь нутаг дэвсгэрт тулгуурласан малчдын оорийгоо удирдах байгууллагын тогтолцоог бий болгон чадавхижуулж, оролцогч, дэмжигч талуудын вйл ажиллагааг дэмжин тусалж, уялдуулан зохицуулснаар Монгол улсын бэлчээрийн тогтвортой

менежментийг толовшүүлнэ.

Алсын хараа:

Эрүүл бэлчээр - Баталгаат амьдрал

Зорилтууд:

- Бэлчээрийн менежменттэй холбогдсон торийн бодлого, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зовломж боловсруулах ажлыг оролцогч талуудын оролцоонд тулгуурлан зохион байгуулж, торийн холбогдох дээд байгууллагад тухай бүр уламжилж, тэдэнтэй хамтран ажиллах;
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмших, хамгаалахад чиглэгдсэн малчдын хамтын үйл ажиллагааг дэмжиж, тэдэнд арга зүй, менежментийн зовлогоо огох үйлчилгээ үзүүлэх;
- Малчдын хэсэг, бүлэг, нохорлол, холбоодын үүсгэл санаачлагыг дэмжиж, бэлчээрийн хамтын менежментийн толовлогоо боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулах;
- Бэлчээрийн менежмент, экологийн боловсрол олгох, малчдын орлого нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр тэдэнд зориулсан сургалтын хотолбор боловсруулж, сертификаттай сургалт явуулах, хялбарчилсан мэдээ, мэдээлэл, материал бэлтгэж, дэлгэрүүлэн түгээх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Малчдын эрх ашгийг хамгаалах сайн дурын байгууллага, нийгэмлэг, нохорлол, холбоог дороос үүсгэн байгуулахад арга зүй, холбогдох мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Бэлчээрийг урт хугацаанд тогтвортой, үр ашигтай ашиглах боломж, нохцол, менежментийн бодлогыг тодорхойлоход чиглэгдсэн судалгаа шинжилгээний ажлыг салбарын эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор хийж, үр дүнг торийн болон холбогдох байгууллагад тайлагнаж, сурталчилан таниулж байх;
- Бэлчээрийн нэгж талбар дахь малчин орх, малчдын холбоо, хэсэг, бүлэг, нохорлолийн орлогыг нэмэгдүүлэхэд гадаад, дотоодын тосол, хотолборийн дэмжлэг туслалцааг чиглүүлэхэд анхааран ажиллах;
- Бэлчээрийн менежментийн оноогийн чиг хандлага, бэлчээрийн толов байдлын талаархи судалгаа шинжилгээний ажлын үр дүнг нийтэд хүртээмжтэй болгох, бэлчээр сайжруулах шинэ технологийг сурталчлан таниулах зорилго бүхий “Бэлчээр-Ногоон Алт” сонинг тогтмол гаргах ба цаашид энэ чиглэлээр сэтгүүл гаргахад бэлтгэх;
- Олон улсын ижил зорилготой байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллах;
- Бэлчээр судлалын эрдэмтэд, судлаачдын судалгааны ажлыг хохүүлэн дэмжиж

мэргэжлийн хувьд осож дэвжихэд нь туслалцаа үзүүлэх.